



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 5/01

Ховд

**Б.Гантөмөрийг ахлах мэргэжилтнээр
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авилгатай тэмцэх газрын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 05/12 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Б.Гантөмөрийг 2022 оны 01 сарын 06-ны өдрөөс эхлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтнээр жинхлэн томилсугай.

2. Б.Гантөмөрийг Төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6-5 дэх шатлал буюу 853375 төгрөг (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав)-өөр цалинжуулж, холбогдох нэмэгдлүүдийг журмын дагуу бодож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг (Б.Гантөмөр)-т даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

- 8400 03 00-3
D/Tush-B/01-Bo